

**Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний  
бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмаар Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх /цаашид “хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх” гэх/-тэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаанд үнэн зөв, шуурхай, ил тод байх, хууль тогтоомжийг сахин мөрдөх зарчмыг баримтална.
- 1.3. Монгол Улсын төмөр замын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагаа нь энэхүү журмын 2.1-д заасан этгээд Олон Улсын төмөр замын гэрээ, хэлэлцээр, төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг, Монгол Улсын хил, гаалийн байгууллагын холбогдох эрх зүйн акт, хилийн төмөр замын өртөөний техник захирамжийн акт, технологийн процесс зэргийг өмчийн төрөл хэлбэр харгалзахгүйгээр мөрдөж ажиллана.
- 1.4. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагааг тухайн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нар харилцан тохиролцон зохион байгуулж, Монгол Улсын хилийн боомт болон хилийн өртөөнд гүйцэтгэнэ.
- 1.5. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхэд дараах Олон улсын гэрээ, хэлэлцээр болон хууль, тогтоомж, дүрэм, протоколын заалтыг баримтална:
  - 1.5.1. Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон Улсын ачааны харилцааны хэлэлцээр” /ОУАХХ/;
  - 1.5.2. Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон Улсын зорчигчийн харилцааны хэлэлцээр” /ОУЗХХ/;
  - 1.5.3. Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон Улсын харилцааны зорчигчийн вагон эдэлгээний дүрэм” /ЗВЭД/;
  - 1.5.4. Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон Улсын харилцааны ачааны вагон эдэлгээний дүрэм” /АВЭД/;

- 1.5.5. Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон Улсын зорчигчийн галт тэрэгний зурмаг тохигох хурал”-ын протокол;
  - 1.5.6. Монгол-Оросын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөлгөөний протокол;
  - 1.5.7. Монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын зөвлөлгөөний протокол;
  - 1.5.8. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол;
  - 1.5.9. Монгол Улсын хилийн төмөр замын өртөөгөөр “Тусгай зориулалтын, олон голт, хүнд даацын, хортой аюултай ачаа тээвэрлэх” дүрэм;
  - 1.5.10. Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм;
  - 1.5.11. Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам;
  - 1.5.12. Төмөр замаар хэтрүү овортой, хүнд жинтэй, урт ачаа тээвэрлэх журам;
  - 1.5.13. Зорчигчийн галт тэрэг дамжуулах технологийн процесс;
  - 1.5.14. Хилийн төмөр замын өртөөний нэгдсэн технологийн процесс;
  - 1.5.15. Хилийн төмөр замын өртөөнд вагонд үзлэг, шалгалт, техникийн үйлчилгээ хийх технологийн процесс;
  - 1.5.16. Төмөр замын тээврийн салбарт нийтээр дагаж, мөрдөхөөр тогтоосон бусад дүрэм, журам.
- 1.6. Төмөр замын тээврийн тухай хууль.
  - 1.7. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхэд дараах стандартын шаардлагыг баримтална:
    - 1.7.1. “Гол замын ба сэлгээний илчit тэрэгний ялгаруулах хорт бодис болон ажилласан хийн утаажилт. Норм хэмжээ ба тодорхойлох арга” MNS 5877:2008;
    - 1.7.2. “Илчit тэрэгний техникийн ерөнхий шаардлага” MNS 6039:2009;
    - 1.7.3. “Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ” MNS 5833:2014;
    - 1.7.4. “Төмөр замын хэрэглээ. Овор-1-р хэсэг: Суурь бүтэц ба хөдлөх бүрэлдэхүүний ерөнхий-нийтлэг дүрэм” MNS EN 15273-1,2,3 :2016

- 1.7.5. “1520 мм-ийн царигтай Төмөр зам. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6229:2010;
  - 1.7.6. “1520 мм-ийн царигтай Төмөр замын ачааны вагоны хоёр голт тэргэнцэр техникийн ерөнхий шаардлага” MNS 6143:2010;
  - 1.7.7. “Төмөр замын ачааны вагон. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6276:2011;
  - 1.7.8. “Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагоны үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5876: 2012;
  - 1.7.9. “Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6312:2012;
  - 1.7.10. “Ачилт буулгалт ба сэлгээний ажлын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага” MNS 3084:2013
  - 1.7.11. “Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Ерөнхий шаардлага” MNS 6466:2016
  - 1.7.12. “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага.” MNS 6630-1,2,3,4:2016.
- 1.8. Монгол Улсын хилийн төмөр замын өртөө нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон хил, гаалийн үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

### **Хоёр. Хамрах хүрээ**

- 2.1 Энэхүү журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид “Хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/, төмөр замын суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.
- 2.2 Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд бүртгэл хөтлөж, хүлээлцэн нэвтрүүлэх ажилтан нь Монгол Улсын хууль тогтоомж, төмөр замын нийтлэг багц дүрэм болон энэхүү журмыг дагаж мөрдөж ажиллана.

## **Гурав. Нэр, томъёо, тодорхойлолт**

3.1 Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр, томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, “Төмөр зам. Хөдлөх бүрэлдэхүүний нэр томъёо, тодорхойлолт” MNS 6387-3:2013 стандартад зааснаар болон дараах утгаар ойлгоно:

3.1.1. **“Төмөр замын хилийн өртөө”** гэж хил гааль, хилийн шалган нэвтрүүлэх болон мэргэжлийн хяналтын алба, төмөр замын байгууллага, хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон бусад үзлэг, шалгалт хийх төмөр замын хилийн өртөөг;

3.1.2. **“Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч”** гэж хууль буюу гэрээний үндсэн дээр хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн мэдэлд эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээдийг;

3.1.3. **“Хөдлөх бүрэлдэхүүн нэвтрэх”** гэж Монгол Улсын хилийн боомтын төмөр замын өртөөгөөр хөдлөх бүрэлдэхүүнийг оруулах, гаргах, дамжин өнгөрүүлэхийг;

3.1.4. **“Бүртгэл хөтлөх”** гэж Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон хоёр талын гэрээ, хэлэлцээр, төмөр замын тээврийн салбарын холбогдох эрх зүйн акт, баримт бичгийн дагуу хүлээн авч, хүлээлгэн өгсөн болохыг бүртгэн баталгаажуулахыг;

3.1.5. **“Хөдлөх бүрэлдэхүүн хүлээлцэх”** гэж хөдлөх бүрэлдэхүүнийг энэ журамд заасны дагуу хүлээн авч, хүлээлгэж өгөх ажиллагааг;

3.1.6. **“Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох”** гэж Монгол Улс төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцуулахаар дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, найдвартай ажиллагааны түвшин өндөр, стандартын шаардлага хангасан зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникт худалдан авч, тэдгээрт “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага” MNS 6630-1,2,3,4: 2016 стандартын шаардлагын тавьсан дугаар, тэмдэглэгээ;

3.1.7. **“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн”** гэж Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд болон хөрш орнуудын төмөр замд ашиглах зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникийг;

3.1.10. **“Гадаад хөдлөх бүрэлдэхүүн”** гэж Монгол Улсад төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож буй Монгол Улсад бүртгэлгүй, гадаад улсын бүртгэлтэй вагоныг тус тус ойлгоно.

## **Дөрөв. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд тавих техникийн шаардлага**

4.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. Хөдлөх бүрэлдэхүүн нь энэхүү журмын 1.3-1.5, 1.6-1.7 заасан хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэн хүлээлцэхэд мөрдөх баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

4.1.2. Хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн байдлыг тодорхойлох техникийн баримт бичиг /гэрчилгээ/-тэй байх;

4.1.3. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацааны 1/3 /гуравны нэг/-ээс хэтрэхгүй байх;

4.1.4. Олон улсын түвшинд зохих засвар үйлчилгээ хийхээр итгэмжлэгдсэн төмөр замын байгууллагаар засвар хийлгэсэн хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн болон тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааны баталгааг тодорхойлсон баримт бичигтэй байх ба түүнийг хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч хариуцах;

4.1.5. Хөдлөх бүрэлдэхүүний дугаар, тэмдэг тэмдэглэгээ нь эрх бүхий байгууллагаас баталсан горим, журам, стандартад нийцсэн байна.

#### **Тав. Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэл хөтлөх**

5.1. Энэхүү журмын 2.1-д заасан этгээд Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүнийг нэвтрүүлж, бүртгүүлэхдээ төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлсэн байна:

5.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шинээр худалдан авах, түрээслэх, ашиглах хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэн бүртгүүлэхдээ иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, бүдүүвч болон гэрэл зураг, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, нөхцөл, шаардлага, засвар, үйлчилгээг хийгдсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг, мөн гэрчилгээ, эзэмших, ашиглахтай холбоотой гэрээний хуулбар зэргийг бүрдүүлэн Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан хүсэлтээр ирүүлнэ. Тус байгууллага болон суурь бүтэц эзэмшигч, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх байгууллагаас зөвлөлгөө авч болно;

5.2. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан хүсэлт, техникийн баримт бичиг, холбогдох мэдээллийг үндэслэн, ажлын хэсгийн бүрэлдэхүүний томилон ажиллаж, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдал нь стандарт, дүрэм, журмын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

5.3. Дүгнэлтийг ажлын хэсгийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд эсрэг саналтай гишүүд энэ тухайгаа дүгнэлтэд тусгаж, гарын үсэг зурсан байна.

5.4. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний талаарх шаардлагатай бүртгэл, мэдээ, тайланг суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч байгууллагаас тухай бүрт нь шуурхай, цахим хэлбэрээр болон албан бичгээр авч, нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, хөтөлж ажиллана.

5.6. Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтэд ашиглахаар урьд нь ашиглагдаж байсан хөдлөх бүрэлдэхүүнийг төмөр замын хилийн өртөөгөөр нэвтрүүлэхдээ техникийн паспорт /гэрчилгээ/, тухайн улсын эрх бүхий байгууллагаас техникийн шаардлага хангаж байгааг тодорхойлсон дүгнэлт болон тэмдэглэл, гаалийн татвар, бусад төлбөр тооцоог зохих журмын дагуу төлснийг нотлох баримт зэргийг бүрдүүлсэн байна.

5.7. Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, мөн тээвэрлэгч нар нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй галт тэрэгний бүрэлдэхүүний бүдүүвчид техникийн болон тээвэрлэлтийн нөхцлөөс хамааран өөрчлөлт оруулбал Хөдөлгөөн зохицуулалтын төвд мэдэгдэж, техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж, явуулна.

5.8 Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний хийцэд өөрчлөлт оруулсан тохиолдолд Төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төвд тус тус мэдэгдэж, гэрчилгээнд тэмдэглэл хийлгэж, ашиглалтын үеийн найдвартай ажиллагааг хангуулсан байна.

### **Зургаа. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэх**

6.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхдээ суурь бүтэц эзэмшигч нь дараах баримт бичгийг хөтлөж ажиллана. Үүнд:

6.1.1. Галт тэрэгний биечилсэн хуудас /энэхүү журмын нэгдүгээр хавсралт/;

6.1.2. Хөдлөх бүрэлдэхүүн дамжуулах хүснэгт /энэхүү журмын хоёрдугаар хавсралт/;

6.1.2. Вагоны дамжуулах хүснэгт /энэхүү журмын хоёрдугаар хавсралт/;

6.1.3. Зүтгүүрийн машинчийн замналын болон зүтгүүрийн хуудас /энэхүү журмын гуравдугаар хавсралт/.

6.2. Монгол Улсын хилээр нэвтэрч буй олон улсын зорчигчийн галт тэргийг хилийн төмөр замын өртөөн дээр үзлэг, шалгалт, техникийн үйлчилгээг хийж, хөдөлгөөний нэгдсэн зурмаг, цагийн хуваарийн дагуу хүлээлцэнэ.

6.3. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийсний дараа вагон дамжуулах хүснэгтэд хоёр талын хилийн өртөөний холбогдох төмөр замын ажилтан гарын үсэг зурсан цаг минутаас эхлэн хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцсэнд тооцно. Орох хилийн өртөөнөөс цааш аялахгүй зүтгүүрийг бүртгэхгүй.

### **Долоо. Хяналт, хариуцлага**

7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв, төмөр замын суурь бүтэц эзэмшигч нар тус тусын эрх үүргийн хэмжээнд хяналт тавина.

7.2. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

7.3. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, ашиглалтын тайланг “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын заасны дагуу авч, хяналт тавина.

7.4 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын төмөр замын тээвэрт шинээр нэвтрүүлэх, мөн ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавина.

7.5. Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, захиалагч нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг олон улсын болон төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй журам, заавар, технологийн дагуу засвар, үзлэг, үйлчилгээнд хамруулж түүний техникийн болон тээврийн аюулгүй байдлыг бүрэн хариуцан ажиллана.

7.5. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ын нэгдүгээр хавсралт

## Галт тэрэгний биечилсэн хуудас

Галт тэрэгний дугаар \_\_\_\_\_ Зүтгүүрийн дугаар \_\_\_\_\_

Галт тэрэг явсан: 201..... оны .... сар.... өдөр ..... цаг .....МИН

Галт тэрэг ирсэн: 201..... оны .... сар.... өдөр ..... цаг .....мин

Галт тэрэг найруулсан өртөөний нэр \_\_\_\_\_ Код \_\_\_\_\_

Галт тэрэг очих өртөөний нэр \_\_\_\_\_ Код \_\_\_\_\_

## Галт тэрэгний бүрэлдэхүүн, жин, урт

Вагоны дугаар	Найруулсан өртөөний нэр				Бүрэлдэхүүн өөрчилсөн өртөөний нэр			
	4 голт		8 голт		4 голт		8 голт	
	Ач	Xoo	Ач	Xoo	ач	Xoo	ач	Xoo
Битүү вагон								
Тавцан вагон								
Хагас вагон								
Цистерн вагон								
Ледник								
Чингэлэг тээгч тавцан								
Тогтмол дулаант вагон								
Хоппер								
Суудлын вагон								
Бусад вагон								
ДҮН								
Галт тэрэгний жин тонноор	Сав	Цэвэр	Бохир		Сав	Цэвэр	Бохир	
Галт тэрэгний урт, томъёолсон вагоноор								Томъёолсон урт

Галт тэрэгний эхний вагон №	
Сүүлийн вагон №	

*Гарын үсэг*

*ДСР.....*  
*Тех. Конт .....*

*Гарын үсэг*

*ДСР.....*  
*Тех. конт.....*

“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний  
бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ын хоёрдугаар хавсралт

### **Вагон дамжуулах хүснэгт**

..... өртөөнөөс ..... өртөөнд № ....-р галт тэргээр хүлээлгэн өгөх вагоны мэдүүлэг

№ д/д	Замын эхний үсгүүд		Вагоны дугаар	Вагоны төрөл		Голын тоо	Ачаатай эсвэл хоосон	Өртөөний нэр	Хүлээн авагч
	нэр	шифр		Нэр	шифр				

Хүлээлгэн өгөгч төмөр замын агент  
Гарын үсэг  
Хүлээлгэн өгөгч төмөр замын тамга  
Хүлээлгэн өгөгч төмөр зам

Хүлээн авагч төмөр замын агент  
Гарын үсэг  
Хүлээн авагч төмөр замын тамга  
Хүлээн авагч төмөр зам

**“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний  
бүртгэл хөтлөх, хүлээндэх журам”-аас ХАССАН ЗААЛТУУД**

**3.1.8. “Монгол Улсын хилээр байнга бус нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн” гэж  
Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд 12 хүртэлх сарын  
хугацаанд ашиглах зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад төхникийг;**

**3.1.8. “Монгол Улсын хилээр байнга бус нэвтэрч буй түрээслэгдсэн хөдлөх  
бүрэлдэхүүн” гэж Монгол Улс болон хөрш орнуудын төмөр замын тээвэрлэлтийн үйл  
ажиллагаанд оролцуулахаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түрээслэсэн зүтгүүр,  
вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад төхникийг; / Ийм хөдлөх бүрэлдэхүүнд шинэ  
дугаар олгохгүй/**

**3.1.9. “Монгол Улсын хилээр анх удаа (импорт) нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн”  
гэж Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч төмөр замын тээвэрлэлтийн үйл  
ажиллагаанд байнга болон байнга бус оролцуулахаар худалдан авсан зүтгүүр,  
вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад төхникийг;**

**3.1.9. “Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч буй худалдан авсан хөдлөх  
бүрэлдэхүүн” гэж Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч төмөр замын тээвэрлэлтийн  
үйл ажиллагаанд байнга болон байнга бус оролцуулахаар худалдан авсан зүтгүүр,  
вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад төхникийг;**

**5.1.2. Монгол Улсын хилээр байнга болон байнга бус нэвтэрч буй хөдлөх  
бүрэлдэхүүний гэрчилгээ, хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмших, ашиглахтай хөлбоөтэй  
гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;**